

Мөнхцоожийн Сугар-Эрдэнэ[✉]

¹Чингис хаан Үндэсний музей,
Монгол улс, Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Ж.Самбуугийн гудамж

Цагаан сайрын хадны зураг

Хураангуй. Тус өгүүлэлд Монгол Алтайн нурууны салбар Жаргалант хайрхан уулын Цагаан сайраас илрүүлсэн хадны зургийн талаар өгүүлнэ. Зохиогч Цагаан сайрын 3 газраас хадны сийлмэл зураг илрүүлж бүртгэсэн нь өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүн болно. Хадны зургийн он цаг, соёлын хамаарлыг ижил төрлийн дурсгалуудтай харьцуулан тодотгов. Энд ан амьтдыг бодит болон загварчлан дүрслэх гэсэн хадны зургийн үндсэн хоёр аргыг ашигласнаас гадна хосолмол болон хосмолжин аргаар дүрсэлсэн зураг цөөн боловч тохиолдож байна. Цагаан сайрын хадны зурагт ан амьтад, тэр дундаа янгирын дүрслэл дийлэнх хувийг эзэлнэ. Монгол орны хадны зурагт янгирыг зурж үлдээх болсон нь дээд палеолитын үеэс эхлэлтэй бөгөөд хөгжингүй болон хожуу хүрлийн үед улам боловсронгуй, олон дүр байдлаар сийлэх болж, дараа дараагийн түүхэн үеүдэд уламжлагдан хөгжжээ. Харьцуулсан судалгааны үр дүнд Цагаан сайрын хадны зургийн дийлэнхийг (96.5 %) хожуу хүрлийн үед хамааруулан үзэж байна. Харин хадны гадарга дээр шаргал өнгөөр ялгагдах цөөн тооны (3.5 %) янгирын дүрслэлийг эртний Түрэгийн үед холбогдуулан үзэв. Цагаан сайрт хожуу хүрлийн үеийн дурсгал болох хиргисүүр цөөнгүй байгаа нь дээрх хадны зурагтай нэг үед хамаарах юм. Энэ нь бидний өгүүлэн буй хадны зургийг үйлдэгчид нь хиргисүүрийн соёлын ард түмэн байж болох юм гэсэн таамаг төрүүлнэ. Үүнийг цаашид лавшруулан судлуустай асуудал бөгөөд энэ удаа зөвхөн таамаг төдийгөөр дурдаж байна.

Түлхүүр үг: Жаргалант хайрхан, Цагаан сайр, хадны зураг, янгирын дүрслэл, хожуу хүрлийн үе

Sugar-Erdene Munkhtsooj[✉]

¹Chinggis Khaan National Museum,
J.Sambuu Street, 4th Khoroo, Chingeltei District,
Ulaanbaatar 15160, Mongolia

Petroglyphs of Tsagaan-sair

Abstract. This paper examines the petroglyphs discovered at Tsagaan Sair, located at Jargalant Khaikhan Mountain, a branch of the Mongolian Altai Range. The principal materials of this study consist of engraved rock images newly identified and recorded from three localities within Tsagaan Sair. The chronology and cultural affiliation of these petroglyphs are clarified through comparative analysis with similar monuments from neighboring regions. The rock art assemblage demonstrates the two principal representational methods commonly observed in petroglyphic traditions: realistic and stylized depictions of animals. In addition, a small number of images executed in combined and semi-combined styles were also identified. Among the depicted subjects, wild animals predominate, particularly representations of ibex. In Mongolian rock art, depictions of ibex originated as early as the Upper Paleolithic period. During the Developed and Late Bronze Age, such imagery became increasingly sophisticated and diversified, and the tradition continued into subsequent historical periods. Comparative analysis indicates that the majority of the Tsagaan Sair petroglyphs (96.5%) should be attributed to the Late Bronze Age. A smaller group of ibex figures (3.5%), distinguishable by their yellowish patination on the rock surface, is tentatively attributed to the Early Turkic period. The abundance of khirigsuurs, characteristic monuments of the Late Bronze Age, in the Tsagaan Sair area corresponds chronologically with the petroglyphs. This suggests that the creators of these rock engravings may have been communities associated with the Khirigsuur cultural tradition.

Keywords: Jargalant khairkhan mountain, Tsagaan-sair, petroglyphs, depictions of ibex, Late bronze age

Удиртгал

Хадны зураг нь эртний нүүдэлчдийн соёл, аж ахуй, шүтлэг бишрэл, урлагийн чадамжийг сэргээн үзэх чухал эх сурвалж болдог. Хадны зургийг зөвхөн дүрслэлийн талаас нь авч үзэх бус бүтээсэн эздийг тогтоож, ямар археологийн дурсгалтай холбогдохыг тодруулах нь чухал юм. Сүүлийн жилүүдэд судлаачид хадны зургийн дурсгалын он цагийг нарийвчлан тогтоох, тархалтын хүрээгээр ижилсэх археологийн дурсгалуудтай уялдуулан судалж эздийг тодруулах, он цагийг тогтооход анхааран ажиллах болсон билээ (Төрбат нар, 2019: 375-382).

Бид энэ өгүүлэлд Монгол Алтайн нурууны зүүн салбар уулсын нэг Жаргалант хайрхан уулын Цагаан сайраас илэрсэн хадны зургийн дурсгалын тухай өгүүлнэ. Хээрийн судалгааны явцад Цагаан сайрын 3 хэсэг газар 168 сийлмэл зураг баримтжуулсныг энд нэгтгэн танилцуулж байна. Ингэхдээ дээрх хадны зургийг дүрсэлсэн арга барилыг бүх талбайгаар хонхойлгох, хадны өнгөн хэсгийг холтчин цоохорлох гэж 2 ангилан үзэв. Харин дүрсэлсэн хэв маягийн хувьд бодит, загварчилсан, хосолмол, хосмолжин гэсэн 4 ялгаатай байдлаар мэдэгдэж байна. Цагаан сайрын хадны зураг нь сэдэв зохиомжийн хувьд ан амьтдыг тайван буйгаар эсвэл ав хомрогод өртөж байгаагаар дүрсэлсэн байх ба аж ахуй, шүтлэг бишрэлийн агуулгатай зураг төдийлөн тааралдсангүй. Тиймээс энэ өгүүлэлд Цагаан сайрын хадны зургийн холбогдох он цагийн хамаарал, соёлын холбогдлыг тодруулан гаргахыг зорьсон болно.

Хадны зургийн судалгааны эх хэрэглэгдэхүүнээс үзэхэд, өгүүллийн гол хэрэглэгдэхүүн болгон авч үзэж буй Цагаан сайрын хадны зурагтай дүрслэл, зохиомж, утга бэлгэдлийн хувьд ижил дурсгалууд нэлээдгүй тааралдаж байна Тэдгээр нь Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Цагаан салаа I, III (Кубарев нар, 2005: 162, 164, 170), Цэнгэл сумын Шивээт хайрхан уул орчмын Хар салаа VII, Цагаан гол (Цэвээндорж нар, 2010: 285, 408) Ховд аймгийн Манхан сумын нутаг Бумбат хайрхан уулын Өлийн ам (Энхтөр, Мөнхбат, 2016: 17), Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутаг Баян-Айраг (Амартүвшин нар, 2013: 141), Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Хөрөөгийн үзүүр (Гантулга нар, 2018: 134), Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвш уул, Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уул (Батболд, 2014: 183), Говь-Алтай аймгийн Халиун сумын нутаг Цагаан гол, Бигэр сумын Хар Аараг, Төв аймгийн бүрэн сумын нутаг Бичигт улаан хад, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хад (Пэрлээ, 1975: 169, 203), Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Хахуулын гол (Эрдэнэбат, 2008: 44), Сүхбаатар

аймгийн нутаг Цагаан элэг, Дорнод аймгийн Баян-Уул сумын нутаг Хар чулуутын (Эрдэнэбат, 2023: 11) хадны зургийн дурсгалт газрууд болно. Эл хадны зургийн дурсгалт газруудын тухай өгүүлсэн мэдээ баримт, судлаачдын санал дүгнэлт нь Цагаан сайрын хадны зургийн он цаг, соёлын хамаарал, утга бэлгэдлийг харьцуулан тодруулах хэрэглэгдэхүүн болж байна.

Судалгааны арга зүй

Цагаан сайрын хадны зургийг зохиогч хайгуул судалгааны явцад илрүүлсэн болно. Хадны зургийн баримтжуулалтыг үйлдэхдээ гэрэл зураг авах, тодорхойлолт бичих, хадны зураг бүхий хавтан чулуу бүрийн солбицлыг байршил тогтоогч багажаар (*GPS ERTEX 32X*) бүртгэн авах замаар гүйцэтгэв. Хээрийн судалгааны явцад буулган авсан гэрэл зургийг Adobe Photoshop болон Sketchbook программ ашиглан гар зураг болгон хувиргав. Хайгуул судалгааны явцад буулгасан гэрэл зургаас хадны зургийн хуулбар буюу гар зураг үйлдэх нь цаг хугацаа хэмнэхийн зэрэгцээ хээрийн нөхцөлд зураглал үйлдэхэд (*гялгар уут, кальки*) гарч болох алдаа мэдгээс зайлсхийх боломжтойгоос гадна олон шат дамжлагатай ажлыг хөнгөвчилж байдаг ба энэ талаар судлаачид нэг бус удаа дурдсан байдаг (Амартүвшин нар, 2013: 130). Хээрийн судалгаагаар бий болгосон хадны зургийн мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон түүхийн шинжлэх ухаан, тэр дундаа хадны зургийн он цаг, соёлын хамаарлыг тогтооход өргөн хэрэглэдэг бусад ижил төрлийн дурсгалуудтай жишин харьцуулах аргыг ашиглав.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Шинээр илрүүлсэн Цагаан сайрын хадны зургийн дурсгал нь энэ өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүн болно. Зохиогч хадны зургийн дурсгалт газрыг өөрийн биеэр илрүүлэн, баримтжуулсан бөгөөд эрдэм шинжилгээний тодорхойлолт үйлдэн судалгааны эргэлтэд оруулж буй юм. Түүнтэй уялдан хүрэл зэвсгийн үеийн хадны зургийн дурсгал, тэр дундаа газар зүй, бүс нутаг, дүр дүрслэлийн хэв шинжийн хувьд ойролцоо Монгол Алтайн нурууны Цагаан салаа, Хар салаа VII, Өлийн амнаас илэрсэн хадны зурагтай харьцуулан үзэв.

Дурсгалт газрын байрлал. Жаргалант хайрхан уул нь Ховд аймгийн Манхан, Чандмань сумын заагт, Хар ус нуурын байгалийн цогцолбор газарт оршдог (*Зураг 1*). Жаргалант хайрхан уулын баруун тал бүхэлдээ Манхан сумын нутагт хамаарах ба Рашаант, Таван түрүү, Өмнөх, Дундах, Улиастай, Нарийн, Цагаан сайр, Хар чулуут зэрэг томоохон салаануудтай, байц их хадтай тул хүний хөлөөс зайдуу газар юм. Энд одоо нэгэнт ховордсон

аргаль, янгир, ирвэс, чоно, хойлог мэтийн амьтад бий. Хамгийн өндөр оргил болох Жааханзын орой нь далайн түвшнээс дээш 3796 метр, үнэмлэхүй өндөр нь 2353 метр ажээ (Монгол Улсын, 2021: 15) (Зураг 2).

Хадны зургийн дурсгалт газар нь Манхан сумын төвөөс зүүн хойш 32 км зайд Цагаан сайр хэмээх баруун зүг хандсан салааны эхэнд байрлах бөгөөд энэ орчмыг ерөнхийд нь "Цагаан сайрын эхэн" хэмээн нэрийддэг байна. Энд 3 хэсэг газарт нийт 168 хадны сийлмэл зураг бий (График 1). Хадны зургийн гол бөөгнөрөл байдаг, өмнө болон хойд талаараа өндөрлөг гүвээгээр халхлагдсан нөмөр өвөлжөөг Завсар өтөг хэмээнэ. Өвөлжөөний арын гүвээний баруун урагш харсан наран ээвэр тал (N47.59027 E92.56890)-д буй бүлэг зургийг 1-р хэсэг, өвөлжөөний урд талын Дунд хамар хэмээх гүвээний баруун биед (N47.58865 E92.56876) байх бүлэг зургийг 2-р хэсэг, Дунд хамраас зүүн хойд зүг сунаан тогтсон өндөрлөг гүвгэр нурууны өвөр (N47.59396 E92.57594)-т буй бүлэг зургийг 3-р хэсэг хэмээн тэмдэглэн баримтжуулав (Зураг 3).

Хэлэлцүүлэг

Хадны зургийг дүрсэлсэн арга барил. Хадны зургийн дурсгалыг дүрсэлдэг арга барил нь сийлмэл, зосон, зураасан, бэхэн гэсэн үндсэн төрлүүтэй. Эдгээр төрлүүдээс хадны сийлмэл зургийг, 1. бодит байдлаар дүрсэлсэн, 2. загварчлан дүрсэлсэн хэмээн үндсэн хоёр том төрөлд ангилан үзэх тогтсон хандлага бий (Цэвээндорж 2019, 145). Түүнчлэн амьтны биеийг бүх талбайгаар нь хонхойлгон сийлэх, зөвхөн гадаад тэгийг хөвөөлж цохих, биеийн аль нэг хэсгийг ялган хонхойлох, хурц үзүүртэй багажаар зурж дүрсэлсэн нарийн зураасан зураг хэмээн дэд төрлүүдэд хувааж үздэг (Батболд 2021, 275). Монголын хадны зургийн судалгаанд хамрагдсан сийлмэл зургийн ихэнхийг, тэр дундаа нийт талбайгаар нь хонхойлгон сийлсэн зургийг зэргэлдээ бүс нутгийн адил төрлийн дурсгалтай харьцуулсан судалгаанд түшиглэн хүрэл зэвсгийн үед холбогдуулан үздэг (Санжмятав 1995, 87-97). Энэ үеийн хадны зургийн үндсэн сэдэв агуулга нь аж байдал, ан гөрөө, дайн тулаан, шүтлэг бишрэл байдаг бөгөөд эдгээрийг зэр зэвсэг, араатан жигүүртэн, тамга тэмдэг, нүүрний баг (царай) зэргээр төлөөлөн харуулах нь бий. Бидний өгүүлэн буй Цагаан сайрын хадны зургийн дурсгал бүхэлдээ сийлмэл зургийн төрөлд хамаарах боловч а. Бүх талбайгаар хонхойлгон сийлсэн, б. Хадны өнгөн хэсгийг холтчин цоохорлох гэсэн хоёр аргаар дүрсэлжээ. Харин амьтдыг дүрсэлсэн хэв маягийн хувьд бодит байдлаар дүрсэлсэн, загварчлан дүрсэлсэн, хосолмол, хосмолжин гэсэн

4 аргад хамаарна. Эдгээрийг тус бүрд нь ангилан авч үзье.

Бүх талбайгаар хонхойлгон сийлсэн зураг. Монгол орноос илэрч олдсон хадны зургийн дурсгалд түгээмэл тохиолддог энэ аргаар Цагаан сайрын хадны зургийн ан амьтдын олонхыг дүрсэлжээ (Зураг 4; 5; 6). Бүх талбайгаар нь хонхойлгон сийлсэн хадны зурагт бодит болон загварчилсан дүрст амьтдын дүрслэл хамаардаг. Эл хоёр арга Цагаан сайрын хадны зурагт ажиглагдаж байгаа хэдий ч загварчилсан, уран сэтгэмжээр дүрсэлсэн зураг тийм ч олон биш аж (Зураг 5. 14, 18). Харин хадны зургийн өөр нэгэн үндсэн арга болох гадаад тэгийг хөвөөлөн цохисон зураг энд үгүй ажээ. Бүх талбайгаар нь хонхойлгон сийлсэн хадны зургийн дотор хадны гадар дээр эрс ялгаран харагдах цайвар, шаргал өнгөтэй дүрслэлүүд байгаа нь хожуу зурагдсан болохыг илтгэнэ. Энэ төрлийн ихэмсэг дүр байдалтай, уран нарийн сийлбэртэй дүрслэлүүдийг эртний улсууд, тэр дундаа эртний Түрэгийн үед холбогдуулан үзэх хандлага бий (Батдалай, Батзориг 2013, 149). Түрэгийн үеийн хадны зурагт хамгийн өргөн тархсан сэдэв зохиомж бол ан гөрөө юм (Батболд 2014, 116-117). Ингэхдээ аливаа амьтдын биеийг бодит байдлаар уран нарийн гоёмсог сийлж эсвэл нарийн үзүүртэй багажаар зурж үзүүлээд ямар нэг хөдөлгөөн хийж буйгаар харуулдаг нь энэ үеийн хадны зургийн нэгэн онцлог аж (Кубарев нар 2005, 110). Цагаан сайрын хадны зурагт дүрслэгдсэн гоёмсог дүртэй цөөн хэдэн янгирын дүрслэл Монгол орны нутагт VI-VIII зууны үед төр улсаа байгуулсан Түрэгийн хаант улсын Ашина овгийн тамгатай ижил буйг дурдах хэрэгтэй. Янгирын сонор, шаламгай байдал, сүрлэг дүр хүмүүсийн харааг эрхгүй татаж, нүүдэлчдийн дунд овгийн тамга болтлоо дээдлэгдэх болжээ. Үүний тод жишээ нь дээрх Ашина овгийн янгир тамга юм.

Хадны өнгөн хэсгийг холтчин цоохорлох. Хадны сийлмэл зурагт амьтдын биеийг бүтэн талбайгаар хонхойлгон сийлэхийн зэрэгцээ биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохиод, их биеийг холтчин цоохорлох арга хэрэглэж байжээ. Энэ арга дээд палеолитын үеийн эртний анчин-түүвэрлэгчдээс (Сугар-Эрдэнэ 2023, 13) эхлээд хүрлийн үеийн нүүдэлчин овог аймгуудын үлдээсэн хадны зурагт цөөнгүй мэдэгддэг. Бидний өгүүлэн буй дурсгалт газар хадны өнгөн хэсгийг холтчин цоохорлож амьтдын их биеийг тоймлон харуулсан зураг цөөн боловч тааралдаж байна (Зураг 4. 1).

Цагаан сайрын хадны зургийн дүрслэлийн хэв маягийн ангилал

Бодит байдлаар дүрслэх. Цагаан сайрын хадны зургийн ихэнх дүрслэл энэ аргад хамаарна.

Энд хүн болоод амьтад тэр дундаа янгирыг бодит байдлаар дүрслэн харуулсан байх нь элбэг тохиолдоно. Мөн ан хийж буй хүний дүрслэлтэй нэг зохиомжид багтаан зурсан морь, янгир, нохой, нум зэргийг хүний биеийн хэмжээтэй харьцуулан бодит байдлаар үзүүлэхийг чухалчилжээ (*Зураг 4. 5, 8, 9*).

Загварчлан дүрслэх. Цагаан сайрын хадны зурагт амьтдын загварчилсан дүрс цөөн бий. Дурсгалт газар бугын дүрслэл нийт 8 байхаас хоёр нь загварчилсан дүрслэлтэй бол янгирын олон янз дүрслэлийн дотор мөн хоёр янгирыг загварчилсан байдлаар дүрслэн үзүүлжээ. Бугыг урт нарийн биетэй, их биеийг дагасан, налуу олон салаа эвэртэй, усны шувуу адил нарийн хошуутайгаар дүрсэлсэн нь хожуу хүрлийн үеийн буган хөшөөний сийлбэртэй ижил юм. Харин янгирыг ороомог бүхий сүрлэг эвэр, эсвэл хос эврийг хондлойтой нийлүүлж, сүүлийг угалзарсан нарийн, урт зураасаар дүрслэн харуулсан байна (*Зураг 5. 14, 18*).

Хосолмол зураг. Цагаан сайрын хадны зурагт нарийн зураасаар зурсан амьтдын тодорхой дүрслэл үгүй тул энд тусгайлсан аргад хамруулан үзсэнгүй. Харин бүтэн биеийг хонхойлгон сийлсэн амьтны дүрслэлтэй хамтатган зурсан нарийн зураасан дүрс тэмдэгтүүд цөөн байгааг хадны зургийн хосолмол төрөлд хамруулан үзлээ. Тухайлбал хадны зургийн 1-р хэсгийн 3-р зурагт буй урвуу харуулан дүрсэлсэн амьтны дээр зууван дугуй хэлбэртэй дүрсийг нарийн зураасаар олон давтан зурснаас гадна 4-р зурагт байгаа араатан амьтны толгойн урд, мөн хүзүүг хөндлөн огтолсон нарийн зураасаар хурц үзүүртэй багажаар сийлжээ (*Зураг 4. 3, 4*). Үүнээс гадна янгир мэт биетэй боловч буга адил олон салаа эвэртэй (*Зураг 5. 2, 17*), үхрийн биед янгирын эвэр зурсан, өөрөөр хэлбэл хоёр амьтны биеийг хамтатган үзүүлсэн зургийг хосолмол төрөлд хамааруулан үзэж болохоор байна (*Зураг 4. 2*).

Хосолмол аргаар дүрсэлсэн зураг. Цагаан сайрын хадны зургийн дурсгалд ан амьтдыг тайван буйгаар, эсвэл ав хоморгод өртөж байгаагаар дүрслэхээс гадна уран сэтгэмжээр дүрслэн харуулсан зураг цөөнгүй бий. Аливаа амьтдыг эсрэг зүг, эсвэл өөд өөдөөсөө харсан байдалтай тэгш хэмтэйгээр урласан тохиолдол хадны зурагт тэр бүр тааралдаад байдаггүй. Бидний өгүүлэн буй хадны зургийн дурсгалт газар ингэж дүрсэлсэн зураг 2 тааралдаж байна. Хадны зургийн 2-р хэсэгт урд хөл, толгойгоор нийлүүлэн зурсан янгирын доод талд хоёр араатан амьтныг эсрэг зүг хандуулан ташуу дүрсэлсэн байна (*Зураг 5. 6*). Эл зургийн ойролцоо жижиг хаднаа хоёр янгирыг өөд өөдөөс нь харсан байдлаар дүрсэлсэн байгаа нь ан амьтдыг тайван

байгаагаар бус ямар нэг уран сэтгэмж, төсөөлөлд оруулан дүрсэлсэн нь мэдэгдэнэ (*Зураг 5. 10*). Эдгээр нь эртний нүүдэлчин овог аймгуудын ертөнцийг үзэх үзэл, уран сэтгэмжийг илтгэх чухал дүрслэл юм. Ан амьтдыг хосмолжин аргаар дүрсэлсэн зураг зөвхөн Монгол Алтайн нуруугаар хязгаарлагдахгүй төв болон говийн бүс, Дорнод Монголын хадны зурагт ч тохиолдож байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвш уул, Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уул (Батболд 2014, 183), Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Хахуулын гол (Эрдэнэбат 2008, 44), Сүхбаатар аймгийн нутаг Цагаан элэг (Батсайхан нар 1998, 278), Дорнод аймгийн Баян-Уул сумын нутаг Хар чулуут (Эрдэнэбат 2023, 11) зэрэг газраас илэрч судалгааны эргэлтэд оржээ. Эдгээрээс Цагаан сайрын хадны зураг дахь хосмолжин аргаар дүрсэлсэн янгир болон араатан амьтдын бодит дүрслэлтэй ижил зураг Тэвш уул, Хахуулын гол, Дэл уулын хадны зурагт тохиолдоно. Эдгээр дурсгалт газруудаас хамгийн эрт үед холбогдох дурсгал нь Хар чулуутын хадны зураг юм. Энэ дурсгал нь он цагийн хувьд дээд палеолитын үед холбогдох (Эрдэнэбат 2023, 11) хэдий ч хос тэмээн хяруулыг өөд өөдөөс нь харуулан дүрсэлсэн байгааг хосмолжин аргад хамруулан үзэж болохоор байна.

Хосмолжин аргаар сийлсэн зураг нь манай орноос илэрч олдсон хадны зургийн дурсгалуудад тодорхой бүс нутгаар хязгаарлагдахгүй бөгөөд тийм ч олон тохиолддоггүй байна. Хосмолжин зургийн тухай судлаачдын олон тайлбар таамаг бий. Тэдгээрээс илүү бодитой, үнэнд ойр байж мэдэх зарим тайлбараас сийрүүлье. Өөд өөдөөсөө тулан мөргөлдөж буй дүрслэл буюу өөрөөр хэлбэл амьтдын халз тулаан нь хур бороо гуйж, ган гачиггүй арвин их ургац авахын бэлгэдэл болох бөгөөд үүнийг батлах сурвалжийн мэдээ сэлт цөөнгүй байдаг. Согд хэл дээр хадгалагдан үлдсэн хур бороо гуйх нэгэн домогт “цагаан зандан” (*белый сандал*) модоор хийсэн савхан дээр морь морьтой, тэмээ тэмээтэй, илжиг илжигтэй, бух бухтай ноцолдон тэмцэж буйг сийлдэг (Benveniste 1940, 134) тухай мэдээ байхаас гадна адуу, тэмээний тулалдааныг шинжиж, ирэх онд ямар ургац хураан авахыг таадаг байжээ (Бичурин 1951, 149). Үүнийг нягтлан үзсэн судлаачид, эртний газар тариалан эрхлэгч ард түмнүүдийн дунд уг төсөөлөл үүсэж хожмоо индоевропчуудын шилжилт хөдөлгөөнөөр дамжин Төв Азийн нүүдэлчдийн соёлд нөлөөлсөн бололтой (Батсайхан нар 1998, 275) хэмээн үзжээ.

Цагаан сайрын хадны зургийн зохиомж, утга зүй

Цагаан сайрын хадны зургийг дүрсэлсэн сэдэв

зохиомжоор нь ан авын сэдэвтэй, бэлгэдлийн агуулгатай гэсэн хоёр төрөлд хуваан үзэж болохоор байна. Бэлгэдлийн агуулгатай дүрслэлд ороомог эвэртэй янгир болон тамга тэмдгийн дүрслэлүүдээс гадна дээр дурдсан хосмолжин аргаар дүрсэлсэн зураг ч багтах юм. Нөгөөтгээгүүр амьтдыг тайван буйгаар дүрсэлж байгаа нь ан гөрөө элбэг, хоол хүнс арвин байхыг бэлгэдсэн хэрэг билээ.

Хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт гол төлөв ан ав, аж байдлын холбогдолтой зураг зонхилдог. Энэхүү тогтсон утга, зохиомж Цагаан сайрын хадны зурагт тусгалаа олсон хэдий ч аж байдал, ахуйн холбогдолтой зураг төдийлөн мэдэгдэхгүй байна. Харин ан авын зохиомжтой дүрслэл хэд хэд байгааг ижил төстэй дурсгалуудтай нь харьцуулан өгүүлбэл дараах байдалтай байна.

Ан авын зохиомжтой дүрслэл. Хадны зургийн 1-р хэсэгт ан хийж буй хүний дүрслэлийг тойм байдлаар сийлсэн тохиолдол 3 байна. Эхний зураг нь, морь унан нум сум агсаж, янгир авлаж буй зохиомжтой хүний зураг юм. Хоёр дахь зураг нь, морь унан янгир авлаж буй зохиомжтой атлаа зэвсэг үгүй ажээ. Гурав дахь дүрслэл нь, нум сум агсан янгир харваж буй хүний дүр юм. Энд хүнийг тойм байдлаар харуулаад нум сумыг тодорхой дүрсэлжээ (*Зураг 4. 5*). Эдгээр зурагт байгаа янгир намагчдын унасан моринд эмээл дүрслээгүй аж (*Зураг 4. 8, 9*). Судлаачид хадны зураг дахь морь унасан хүний зургийг хүрлийн эхэн үеэс хойш холбогдуулан үздэг бол морь унан нум сумаар ан хийж буй хүний дүрслэлийг хөгжингүй болон хожуу хүрлийн үед хамааруулан үздэг (Батболд 2014, 110). Хүрэл зэвсгийн үеийн овог аймгууд нэг газраа удаан суурьшдаггүй, үргэлж шилжилт хөдөлгөөн хийж, нүүдэллэх амьдралын хэв маягтай байсны хувьд ан ав, ахуйн хэрэгцээ, нийгмийн харилцаанд адуу чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Адууг гаршуулж өөрийн хэрэглээндээ ашиглах болсноор өдөр тутмын үйл явдлыг хөнгөвчлөөд зогсохгүй нутаг бүрийн түгжигдмэл явцуу байдлыг эвдэж хөрш зэргэлдээ, алс холын овог аймгуудтай харилцах соёл ихээхэн тэлэх нэгэн шалтгаан болжээ (Монгол Улсын түүх 2004, 169). Харин хөгжингүй болон хожуу хүрлийн үеийн хадны зургуудаас үзэхэд гаршуулсан адуу нь анхандаа дайн тулаан, худалдаа, арилжаа гэхээс илүүтэй ан ав болоод мал адгуулах зэрэг ахуйн хэрэгцээт ажлыг гүйцэтгэх нэгэн чухал дэвшил байсныг харж болох юм. Энэ байдал бидний дурдан буй Цагаан сайрын хадны зурагт буй тул ан авын зохиомжид багтаан үзэв.

Цагаан сайрын хадны зурагт буй нэг сонирхолтой өгүүлэмж бол нохойтой авын дүрслэл юм. Хадны зургийн 2-р хэсэгт, урагш харсан босоо хадны дээд захад цувран явж буй

хоёр янгир, түүний хойноос хөөж байгаа нэг нохой дүрсэлсэн байна. Уг нохойны хойно хоёр хүний тойм дүрслэл байгааг нарийн зураасаар нохойны их бие болон хойд хөл орчимтой холбон зуржээ. Босоо байдалтай дүрсэлсэн хоёр хүний гартай холбон зурсан нарийн зураасыг ан хийхдээ ашиглаж буй жад хэмээн үзэж болох ч нохойтой холбосон байгаа нь анхаарал татна. Энэ нь магадгүй ан гөрөөний үед нохой хөтөлж, улмаар ан ав руу суллан тавьж буйг харуулсан дүрслэл байж болох юм (*Зураг 5. 1*). Ан авын үед нохойг уяагаар тогтоон барьж, оосорлож явах нь ан амьтдыг үргээх, хүний төлөвлөөгүй илүү хөдөлгөөн хийхээс болгоомжлох нэгэн арга юм.

Хадны зургийн дурсгалт газруудад байх онцлог дүрслэлүүд тухайн дурсгалын он цагийг тогтоох нэгэн баримжаа болж өгдөг. Үүнтэй уялдуулан хадны зурагт нохой дүрслэх болон нохойгоор ан хийлгэж буй зохиомжтой зураг дүрслэл, түүний он цагийн талаар дэлгэрүүлж үзье.

Монгол орны нутаг дэвсгэрээс илэрсэн хадны зургийн дурсгалт газруудад нэлээд түгээмэл, басхүү онцгой үүрэгтэйгээр дүрслэгдсэн амьтан бол нохой юм. Манай орноос илэрч олдсон хадны зургуудаас хамгийн эрт үед холбогдох нохойн дүрслэл Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Баян-Өлзийт уулнаас илрүүлсэн зосон зурагт бий. Судлаачид уг нохойны дүрслэлийг неолитын үед холбогдуулан үзжээ (Болорбат, Бадма-Оюу 2014, 137-138). Мөн Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн суурины ТВ13 дугаартай хагас газар сууцны үлдэгдлээс бүтэн нохойны яс анхны тавилтаараа илэрчээ. Үүнийг судлаачид гэршүүлсэн нохой байх бүрэн үндэслэлтэй талаар дурдсан бөгөөд эцсийн үр дүн хэвлэгдээгүй байна (Одсүрэн нар 2022, 43). Эдгээр баримтууд нь нохой гэршүүлсэн цаг хугацаа неолитын үед тохиосныг бататгаж буй хэрэг юм. Харин хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт нохой дүрслэн сийлэх явдал элбэг болсны дээр олон янзын утга агуулгатайгаар харуулах болжээ. Гэсэн хэдий ч нохойг тайван буйгаар дүрслэхээс илүүтэй ан гөрөөний сэдэв зохиомжид оруулан дүрсэлсэн байх нь элбэг. Энэ нь хүн төрөлхтөн нохойг ан авд сургах, араатан амьтдаас өөрсдийгөө хамгаалахаар сургаж байсан хэмээн үзэх нэгэн баримт болдог.

Манай орны хадны зургуудад нохойгоор ан хийлгэж буй сэдэв зохиомжтой зураг нэлээдгүй илэрч судлагдсан байдгаас онцлог зарим нэг дурсгалыг дурдвал, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Цагаан салаа I, III (Кубарев нар 2005, 162, 164, 170), Цэнгэл сумын Шивээт хайрхан уул орчмын Хар салаа VII, Цагаан гол (Цэвээндорж нар 2010, 285, 408) Ховд аймгийн Манхан сумын нутаг Бумбат хайрхан уулын Өлийн ам (Энхтөр, Мөнхбат 2016, 17), Дундговь аймгийн Өлзийт

сумын Дэл уул (Баттулга, Анхсанаа 2015, 11)-ын дурсгалуудыг нэрлэж болно.

Эдгээр дурсгалт газраас Хар салаа VII, Цагаан салаа I талбай болон Өлийн амны дурсгалт газар буй ан амьтан хөөж байгаа нохой болон түүнтэй нэг зохиомжид багтаан зурсан хүний дүрслэлүүд Цагаан сайрын хадны зурагтай нэлээд төстэй байгааг дурдууштай. Хар салаа VII талбайд буй хадны зурагт гараа алдалж, бага зэрэг бөхийн зогссон хүний нэг гарын тохой орчмоос урт зүйл унжуулан дүрсэлжээ. Харин тухайн хүний нөгөө гараас хоёр салаа нарийн зураас салаалуулан дүрслээд нэг үзүүрийг нохойны хүзүүтэй, нөгөө үзүүрийг янгирын эрүү орчимтой холбон үзүүлжээ. Энэ нь нохойг хүзүүнээс нь оосорлон явж буйг тод харуулах нэгэн баримт болж байна. Харин хүнийг янгиртай холбон зурсан байгаа нь шууд илэрхийлэл гэхээс илүүтэй анчны цаашдын үйлдлийг тодруулан харуулах гэсэн бололтой. Өөрөөр хэлбэл нохой хөтөлсөн анчин цаана харагдаж буй янгирыг авлах гэж байгааг зураасаар холбон үзүүлжээ (*Зураг 7. 1*). Харин Цагаан салаад байх хадны зурагт хоёр бугыг хагас дугуйран хашсан байдалтайгаар хөөж буй 6 нохой, эдгээрийн эсрэг талд бас нэгэн нохойг амдан тосож байгаагаар дүрсэлжээ. Цагаан салаад буй дээрх дүрслэл болон ижил төстэй утга агууламжтай дүрслэлүүдийн он цагийн талаар судлаачид НТӨ III–II мянганаас эртний скифийн үе хэмээн ерөнхийлөн авч үздэг (Кубарев нар, 2005: 98, 102). Энэ дүрслэлд бугыг усны шувуу адил нарийн эсвэл урамдаж буй мэт хошуутай сийлснийг ихэд анхааран тэмдэглэсэн байх ба ийм арга барилаар зурагдсан хадны зургийг судлаачид хөгжингүй болон хожуу хүрлийн үед холбогдуулан үзэх нь бий (Төрбат нар, 2009: 69-70).

Бумбат хайрхан уулын Өлийн амны дурсгалт газар нь бидний дурдан буй Жаргалант хайрхан уултай залган оршдог. Өлийн амны хадны зурагт дүрслэгдсэн янгир, нум сум барьсан анчдын тойм дүрслэл болон нохойны бодит дүрслэл нь Цагаан сайрын хадны зургийн зохиомжтой ижил юм (*Зураг 7. 2, 3*).

Хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт нохой, чоныг дүрслэх явдал элбэг тохиолддог. Үүнээс ан авын зохиомжид багтаан зурсан нохойн дүрслэл дийлэнх хувийг эзлэх бол чоно ан хийж буй зураг харьцангуй цөөн тохиолддог. Нохойг харьцангуй жижиг биетэй, толгой өргөсөн байдалтай, гогцооруулан өргөсөн сүүлтэй дүрсэлдэг бол чоныг илүү араатанлаг хэв шинж, дүр байдалтай тодотгон зурсан байдаг. Үүнийг Цагаан сайрын хадны зурагт буй янгир хөөж байгаа 3 чонын дүрслэлээс тодорхой харж болно (*Зураг 5. 20*).

Янгирын дүрслэл. Цагаан сайрын хадны зургийн дурсгалд бодит байдлаар тоймлон

сийлсэн янгирын дүрслэл дийлэнх хувийг эзэлнэ (*График 1*). Эдгээр дүрслэл дотор янгирын ямар нэг эрхтнийг онцлон тодотгосон эсвэл гоёмсог байдалд оруулж дүрсэлсэн нь харьцангуй цөөхөн байна. Энэ мэт олон давтагдаж буй амьтны дүрслэлийг энгийн, бодит байдлаар сийлэх нь ан ав арвин, олз омог их байх гэсэн бэлгэдлийн чанартайгаар дүрсэлж буйн хувьд хэт гоёмсог, загварт оруулахаас илүүтэй бодит байдлаар сийлэхэд анхаардаг байсан бололтой. Эдгээр янгирын олон янз дүрслэлийн дотор өсөн үржихийн бэлгэдэл, агуулгатай зураг ч тохиолдож байна. Тухайлбал, хадны зургийн 1-р хэсэгт хажуугаас нь харсан байдалтай, бүтэн талбайгаар сийлсэн янгирын нуруу болон эврийн хооронд бас нэгэн жижиг янгир дүрсэлжээ (*Зураг 4. 11*). Мөн хадны зургийн 2-р хэсэгт буй сүрэг янгирын дүрслэлээс хамгийн доод захад буй янгирын гэдэс дор мөн нэгэн жижиг янгир зурсан байна (*Зураг 18*). Энэ хоёр тохиолдол нь эхийгээ дагалдан явж буй янгирын төлийг дүрсэлсэн явдал юм. Иймэрхүү байдлаар давхарлан зурсан том жижиг янгир, адууны дүрслэлийг судлаачид загварчилсан байдлаар дүрсэлсэн хэмээн (Батболд 2014, 78-79) зурсан арга барилыг тодорхойлсон байдаг. Энэ нь хэдий загварчилсан уран сэтгэмжийн илэрхийлэл мөн боловч тухайн амьтдын биеийн хэмжээг харгалзан үзэх нь зүйтэй. Цагаан сайрын хадны зурагт давхарлан дүрсэлсэн янгирын дүрслэл хоёр байгаа нь биеийн хэмжээний хувьд том, жижиг байна. Энэ нь бидний дэвшүүлсэн янгир, түүний үр төлийг хамтаар нь зурсан гэсэн саналыг бататгаж буй хэрэг юм.

Үхэр. Цагаан сайрын хадны зурагт үхрийн дүрслэл 3 байна. Үхрийг дүрслэхдээ бүх талбайгаар нь хонхойлгон цохиж сийлэх нэг үндсэн аргаар дүрсэлсэн боловч үхрийн биеийн хэлбэр, зурсан хэв маяг ялгаатай юм. Хадны зургийн 1-р хэсэгт дүрслэгдсэн хоёр үхрийн дээд талын, зүүн зүг харан зогсож байгаа үхрийг өргөн сүүлтэй, хотгор нуруутай, том цээжтэй, бахим хүзүүтэй, монхор хошуутай, эврийн үзүүрийг нь ар тийш ялимгүй махийлгаж, хөл доогуур газар дүрсэлсэн бололтой нарийн зураас гаргажээ. Эл үхрийн биеийн хэлбэрээс үзвэл эр хүйсийн буюу “бүх” болохыг төвөггүй таньж болох юм. Харин доод талд буй баруун зүг хандуулан сийлбэрлэсэн үхрийг нарийн хошуутай, урт чихтэй, том биетэйгээр дүрслээд, дөрвөн хөлийг харуулахаас гадна хойд хөл орчимд бас нэгэн зураас нэмэн зурсан байна. Уг үхрийн эврийг дүрслэхдээ янгирын эвэр мэт тахийсан сүрлэгээр үзүүлж нэг талд нь олон иржгэр нугалаа гаргасан байгаа нь сонирхолтой. Уг үхрийн хошуунаас урт иштэй, тэрэгний дугуй адил хэгээстэй зүйл унжуулан дүрсэлсэн байгаа нь чухам юу болох нь тодорхойгүй юм (*Зураг*

4. 2). Гурав дахь үхрийг солбисон босоо (ацан) эвэртэй, нарийн сүүлтэй, эгц хажуугаас нь харсан байдлаар дүрслэн үзүүлжээ (Зураг 4. 7).

Буга. Цагаан сайрын хадны зурагт буга дүрсэлсэн тохиолдол 8 байна. Эдгээрийг дүрслэхдээ бүх талбайгаар нь хонхойлгон цохиж сийлжээ. Харин зурсан хэв маягийн хувьд загварчилсан (Зураг 4. 4; 5.19), хосолмол (Зураг 4. 4; 5. 2, 17, 20), бодит байдлаар дүрслэн (Зураг 6. 1) үзүүлжээ. Эдгээр дүрслэлийн талаар дээр дурдсан тул энд нэмэн өгүүлсэнгүй.

Тамга, тэмдэг. Цагаан сайрын хадны зурагт тамга, тэмдгийн холбогдолтой дүрслэл 4 бий. Эдгээр нь иштэй дамар хэлбэрийн тамга 1 (Зураг 5. 2), туухай буюу чагтан тамга 1 (Зураг 4. 9), онги тамга мэт дугуй дүрслэл 2 (Зураг 5. 5, 18) зэрэг болно. Манай орноос илэрсэн хадны зургийн дотор иштэй болон ишгүй дамар хэлбэрийн тамга цөөнгүй тааралддаг. Ийм тамга дүрсэлсэн хадны зураг Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутаг Баян-Айраг (Амартүвшин нар, 2013: 141), Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Хөрөөгийн үзүүр (Гантулга нар 2018, 134), Говь-Алтай аймгийн Халиун сумын нутаг Цагаан гол, Бигэр сумын Хар Аараг, Төв аймгийн Бүрэн сумын нутаг Бичигт улаан хад, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хад (Пэрлээ 1975, 169, 203) зэрэг газраас илэрч судалгааны эргэлтэд орж байжээ. Харин дугуй буюу онги тамга дүрсэлсэн хадны зураг нэлээдгүй байдгаас Ховд аймгийн Дарви сумын Байшин үзүүрийн Цагаан толгой, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хад, Төв аймгийн Бүрэн сумын Бичигт улаан хад (Пэрлээ 1975, 169) зэрэг газрыг төлөөлүүлэн дурдаж болох юм.

Хадны зурагт урвуу харуулж дүрсэлсэн ан амьтдын дүрслэл мэр сэр тохиолддог. Цагаан сайрын хадны зурагт урвуу харуулж дүрсэлсэн нэг тохиолдол байгаа нь чухам ямар амьтан болох нь тодорхойгүй юм (Зураг 4. 3). Ингэж дүрслэх явдал нь энгийн буюу тайван байгаа амьтдын төрх байдлыг илэрхийлэхээс илүүтэй өөр утга санааг агуулж байдаг аж. Судлаач А.Д.Грач угсаатны зүйн мэдээ баримтад тулгуурлан “хадны зурагт урвуу харуулан дүрсэлсэн амьтад нь үхсэн болохыг илэрхийлдэг” гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Бид үүнтэй санал нэгдэж байгаа бөгөөд ан ав, дайн тулааны сэдэвтэй хадны зурагт урвуу харуулж дүрсэлсэн тохиолдол ганц биш тохиолддог нь үүнийг давхар бататгах аж (Кубарев нар 2005, 148; Сүхбаатар 2016, 53; Цэрэндагва, Цэвээндорж 2025, 179).

Цагаан сайрын хадны зургийн он цаг ба товч дүгнэлт

Хадны зургийн судалгааг дурсгалт газар,

онцлог дүр дүрслэлээр авч үзэх нь түгээмэл байдаг. Цагаан сайрын хадны зураг нь судалгааны эргэлт, мэдээллийн санд шинээр нэмэгдэж буй дурсгал тул судалгааны чухал ач холбогдолтой. Хадны зургийн дурсгалт газрын он цагийг тогтооход нэн түрүүнд дүр дүрслэл болоод сийлсэн арга барилыг чухалчлан үздэг. Зарим тохиолдолд онцлог дүр дүрслэлүүдийг ижил төрлийн дурсгалуудтай харьцуулан он цагийн хамаарлыг тогтоох нь ч бий. Бид Цагаан сайрын хадны зургийн дүрслэлийн онцлог, сийлсэн арга барил зэргийг дээр харьцуулсан байдлаар дурдсан тул энд зөвхөн он цагийн талаар өгүүлэе. Бүх талбайгаар нь хонхойлгон сийлсэн амьтдын бодит дүр дүрслэл бүхий дурсгалт газруудын олонх нь хүрэл зэвсгийн үед хамаардаг. Цагаан сайрын хадны зурагт буй нохойгоор ан хийлгэж байгаа болон морь унан ан хийж буй дүрслэл нь гол төлөв хөгжингүй хүрлийн үеийн хадны зурагт тохиолддог байна. Мөн янгир авлаж байгаа нум сум барьсан, морьтой анчдын дүрслэл ч энэ үед холбогдох боломжтой юм. Цагаан сайрын хадны зургийн дүрслэл, утга агууламжтай ижил дүрслэл Бумбат хайрхан уулын Өлийн амнаас илэрсэн тухай дээр өгүүлсэн ба уг дүрслэлийн он цагийг НТӨ 3000-1000 жил хэмээн цаг хугацааны нэлээд өргөн хүрээлэлд багтаан үзсэн байна. Эл дурсгал нь газар зүйн болон дүрслэлийн хувьд бидний өгүүлэн буй хадны зургийн дурсгалтай нэг цаг үед хамаарах боломжтой хэмээн бид үзлээ.

Хадны зургийн дотор цөөн боловч тохиолдож буй бугын загварчилсан дүрслэл он цагийн хамаарлыг тогтоох нэг сэжиг болно. Энэ нь хожуу хүрлийн үед хамаарах буган чулуун дээрх загварчилсан бугын дүрслэлтэй ижил байгааг анхаарууштай. Мөн Цагаан сайрын хадны зурагтай зэрэгцэн хиргисүүр цөөнгүй байгаа нь хожуу хүрлийн үед хамааруулан үзэх саналыг бататгах бас нэгэн үндэслэл болж байна.

Эцэст нь дүгнэхэд, Цагаан сайраас шинээр илэрсэн дээрх 3 газарт байх нийт дүрслэлийн 96.5 хувь буюу 162 дүр, дүрслэлийг хожуу хүрлийн үе (НТӨ XIV-VIII зуун)-д холбогдуулан үзэж байна. Харин хадны гадарт нэлээд борлосон зураг дүрстэй зэрэгцүүлэн ихэмсэг байдлаар зурсан янгирын дүрслэл болон шаргал өнгөөр ялгаран харагдах (нийт дүрслэлийн 3.5%) цөөн хэдэн үл мэдэгдэх дүрслэл (Зураг 4. 8; 5. 2, 14; 6. 2-т өөр өнгөөр ялган зурсан) НТ VI-VIII зууны үед холбогдох боломжтой хэмээн үзлээ. Харин газар зүйн байрлалын хувьд хадны зургийн 3-р хэсэгт байх нөмөр атлаа харууцтай, өргөн, тэгш талбайтай газар нь тухайн үеийн овог аймгийнхны тахил, тайлга үйлдэхээр олноор цуглардаг нэгэн газар байсан бололтой. Улмаар энд буй том, хавтгай, толигор хаднаа олон зураг дүрс, тамга тэмдэг

сийлэн үлдээсэн нь бидний үед хадгалагдан иржээ (Зураг 6). Нэмэн өгүүлэхэд Цагаан сайрын хадны зургийн дийлэнх дүрслэлд мэдэгдэж буй олон жижиг цэг мэт хонхорхойнууд нь сийлэх явцад үлдсэн ором бөгөөд хурц үзүүртэй хатуулаг сайтай багажаар сийлсний ул мөр болно. Харин Цагаан сайрын хадны зургийг дүрслэн үлдээсэн эздийг энэ дурсгалт газар буй хиргисүүрийн соёлыг үлдээгч овог аймгийнхантай холбоотой хэмээн таамаглаж байна. Энэ нь эцэслэн шийдэгдсэн асуудал биш хэдий ч хиргисүүр болоод Цагаан сайрын хадны зургийн он цаг давхцаж буй нь ингэж үзэх нэгэн сэжиг болно.

НОМ ЗҮЙ

Амартүвшин Ч., Галдан Г., Ишцэрэн Л. Баян-Айраг, Баруун Бор толгой орчимд шинээр илрүүлсэн хадны зургийн дурсгал. *Studia Archaeologica*, Tomus XXXIII, fasc. 8, Улаанбаатар, 2013: 130-144.

Батболд Н. Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. Улаанбаатар, 2014: 78-79, 110, 116-117, 183.

Батболд Н. Хадны зургийн үйлдэх аргууд. Монголын Археологийн нэвтэрхий толь. Улаанбаатар, 2021: 275.

Батдалай Б., Батзориг О. Ханбогд сумын нутагт шинээр олдсон хадны зургийн тухай. *Studia Archaeologica*, Tomus XXXIII, fasc. 9, Улаанбаатар, 2013: 143-156.

Батсайхан З., Эрдэнэбат У., Төрбат Ц. Цагаан элгийн хадны зураг. *Эрдэм Шинжилгээний Бичиг*, №4, Улаанбаатар, 1998: 266-279.

Баттулга Ц., Анхсанаа Г. Дэл уулын түүх, соёлын дурсгал. Улаанбаатар, 2015: 11.

Бичурин Н.Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. *Вестник Древней Истории*. Санкт-Петербург, 1951: 149.

Болорбат Ц., Бадма-Оюу Б. Баян-Өлзийт уулын хадны зосон зураг. *Studia Archaeologica*, Tomus XXXIV, fasc.11, Улаанбаатар, 2014: 137-141.

Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Магай Ж. Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа. Хойд Тамирын хөндий дэх археологийн судалгаа-II. Улаанбаатар, 2018: 134.

Кубарев В.Д., Цэвээндорж Д., Якобсон Э. 2005. *Петроглифы Цагаан-Салаа и Бага-Ойгура (Монгольский Алтай)*. Новосибирск – Улан-Батор-Юджин, 2005: 98, 102, 110, 148, 162, 164, 170.

Монгол Улсын түүх. Тэргүүн боть (Нэн эртнээс XII зуун). Улаанбаатар, 2005: 169. Ботийн редактор Д.Цэвээндорж.

Монгол Улсын Үндэсний атлас. Улаанбаатар, 2021: 15. Ерөнхий редактор Н.Орших.

Одсүрэн Д., Яанз Л., Адъяасүрэн М., Сугар-Эрдэнэ М., Дашзэвэг Б. Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа төсөл: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Зараа уул, Дорнод аймгийн Халхгол сумын Тамсагбулагт 2022 онд хийсэн археологийн малтлага судалгааны тайлан. Улаанбаатар, 2022: 43.

Пэрлээ Х. Монгол түмний гарлыг тамгаар хайж судалх нь. Улаанбаатар, 1975: 169, 203.

Санжмятав Т. Монголын хадны зураг. Улаанбаатар, 1995: 87-97.

Сугар-Эрдэнэ М. Хадны зураг дахь гахайн дүрслэл. *Studia Archaeologica*, Tomus XLIII, fasc. 2, Улаанбаатар, 2023: 12-20.

Сүхбаатар Д. Дэл уулын хадны зураг. Улаанбаатар, 2016: 53.

Төрбат Ц., Баяр, Д., Цэвээндорж, Д., Баттулга, Ц., Баярхүү, Н., Идэрхангай, Т., Жискара, П. Монгол Алтайн археологийн дурсгалууд I. Баян-Өлгий аймаг. Улаанбаатар, 2009: 69-70.

Төрбат Ц., Батболд Н., Өмирбек Б., Бемманн Я. Хэмцэгийн хадны зургийн судалгааны ангийн 2019 оны хээрийн шинжилгээний урьдчилсан үр дүн. *Монголын Археологи 2019. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, Улаанбаатар, 2019: 375-382.

Цэвээндорж Д., Кубарев В.Д., Якобсон Э. Шивээт хайрхны хадны зураг. Улаанбаатар, 2010: 285, 408.

Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 2019: 113, 145.

Цэрэндагва Я., Цэвээндорж Д. Их баян уулын Бичигтийн амны хадны зураг. Улаанбаатар, 2025: 179.

Энхтөр Ч., Мөнхбат Ц. Бумбат хайрхан уулын хадны зургийн судалгааны эхний үр дүнгээс. *Археологи, түүх, Хүмүүнлэгийн ухааны сэтгүүл*, №12(11). Улаанбаатар, 2016: 13-20.

Эрдэнэбат У. Хахуулын голын хадны зураг. *Studia Archaeologica*, Tomus XXVI, fasc. 3, Улаанбаатар, 2008: 32-56.

Эрдэнэбат У. Хар чулуутын палеолитын хадны зураг. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 12, No. 1, Улаанбаатар, 2023: 11-26. <https://doi.org/10.22353/mjae.2023120101>

Benveniste É. *Textes Sogdiens. Mission Pelliot en Asie Centrale, III*. Paris, 1940: 134.

REFERENCES

Amartuvshin, Ch., Galdan, G., and Ishtseren, L. “Bayan-Airag, Baruun Bor tolgoi orchimd shineer ilruulsan hadny zurgiiin dursgal.” *Studia Archaeologica* 33, no. 8 (2013): 130–144. Ulaanbaatar.

- Batbold, N. *Mongolyn goviin busiin hadny zurgiiin sudalгаа*. Ulaanbaatar, 2014: 78–79, 110, 116–117, 183.
- Batbold, N. “Khadny zurgiiin uildekh arguud.” In *Mongolyn Arkheologiin neverterkhii toli*, 275. Ulaanbaatar, 2021.
- Batdalai, B., and Batzorig, O. “Khanbogd sumyn nutagt shineer oldson hadny zurgiiin tuhai.” *Studia Archaeologica* 33, no. 9 (2013): 143–156. Ulaanbaatar.
- Batsaikhan, Z., Erdenebat, U., and Turbat, Ts. “Tsagaan elgiin khadny zurag.” *Erdem Shinjilgeenii Bichig* no. 4 (1998): 266–279. Ulaanbaatar.
- Battulga, Ts., and Ankhsanaa, G. *Del uuliin tuukh, söliin dursgal*. Ulaanbaatar, 2015, 11.
- Bolorbat, Ts., and Badma-Oyu, B. “Bayan-Ölziit uuliin khadny zoson zurag.” *Studia Archaeologica* 34, no. 11 (2014): 137–141. Ulaanbaatar.
- Gantulga, J., Yeroöl-Erdene, Ch., and Magai, J. “Khöröogiin üzüüriin hadny zurgiiin sudalгаа.” In *Khoid Tamiriin khöndii dekh arkheologiin sudalгаа-II*, 134. Ulaanbaatar, 2018.
- Mongol Ulsyn tuukh. *Mongol Ulsyn tuukh. Terguun boti (Nen ertnees XII zuun)*. Edited by D. Tseveendorj. Ulaanbaatar, 2005, 169.
- Mongol Ulsyn Ündesnii atlas. *Mongol Ulsyn Ündesnii atlas*. Edited by N. Orshikh. Ulaanbaatar, 2021, 15.
- Odsuren, D., Yaanz, L., Adyaasuren, M., Sugar-Erdene, M., and Dashzeveg, B. “Govi, kheeriin bus nutgiin neolityn sudalгаа тösöl: Sükhbaatar aimgiin Tüvshinshiree sumyn Zараа uul, Dornod aimgiin Khalkhgol sumyn Tamsagbulagt 2022 ond khiisen arkheologiin maltlaga sudalгааany tailan.” Ulaanbaatar, 2022, 43.
- Perlee, Kh. *Mongol tumnii garlyg tamgaar khajj sudalkh ni*. Ulaanbaatar, 1975, 169, 203.
- Sanjmyatav, T. *Mongolyn khadny zurag*. Ulaanbaatar, 1995: 87–97.
- Sugar-Erdene, M. “Hadny zurag dakh gakhain dürslel.” *Studia Archaeologica* 43, no. 2 (2023): 12–20. Ulaanbaatar.
- Sukhbaatar, D. *Del uuliin khadny zurag*. Ulaanbaatar, 2016, 53.
- Turbat, Ts., Bayar, D., Tseveendorj, D., Battulga, Ts., Bayarkhuu, N., Iderkhangai, T., and Jiskar, P. *Mongol Altaïн arkheologiin dursгалууд-I. Bayan-Ölgii aimag*. Ulaanbaatar, 2009: 69–70.
- Turbat, Ts., Batbold, N., Ömirbek, B., and Bemann, Ya. “Khemtsegiin khadny zurgiiin sudalгааany angiiin 2019 ony kheeriin shinjilgeenii uridchilsan ür dün.” In *Mongolyn Arkheologi 2019. Erdem shinjilgeenii khurlyn emkhetgel*, 375–382. Ulaanbaatar, 2019.
- Tseveendorj, D., Kubarev, V. D., and Yakobson, E. *Shiveet khairkhny khadny zurag*. Ulaanbaatar, 2010: 285, 408.
- Tseveendorj, D. *Mongolyn ertnii urlagiin tuukh. Nemj zasvarlasan khoer dakh khevlel*. Ulaanbaatar, 2019: 113, 145.
- Tserendagva, Ya., and Tseveendorj, D. *Ikh Bayan uuliin Bichigtiin amny khadny zurag*. Ulaanbaatar, 2025: 179.
- Enkhtur, Ch., and Munkhbat, Ts. “Bumbat khairkhan uuliin khadny zuragiin sudalгааany ekhnii ür dūngees.” *Arkheologi, tuukh, Khümüünlegiin ukhaanysetguul* 12, no. 11 (2016): 13–20. Ulaanbaatar.
- Erdenebat, U. “Khakhuulyn golyn khadny zurag.” *Studia Archaeologica* 26, no. 3 (2008): 32–56. Ulaanbaatar.
- Erdenebat, U. “Khar Chuluutyn paleolityn khadny zurag.” *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology* 12, no. 1 (2023): 11–26. Ulaanbaatar. <https://doi.org/10.22353/mjaae.2023120101>
- Bichurin, N. Ya. “Sobranie svedenii o narodakh, obitavshikh v Srednei Azii v drevnie vremena.” *Vestnik Drevnei Istorii*. St. Petersburg, 1951: 149.
- Kubarev, V. D., Tseveendorj, D., and Yakobson, E. *Petroglify Tsagaan-Salaa i Baga-Oigura (Mongol'skii Altai)*. Novosibirsk–Ulaanbaatar–Yuzhin, 2005: 98, 102, 110, 148, 162, 164, 170.
- Benveniste, É. *Textes Sogdiens. Mission Pelliot en Asie Centrale, III*. Paris, 1940: 134.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>




Зураг 1. Жаргалант хайрхан уул. Цагаан сайрын салаа




Зураг 2. Монгол Улсын газрын зурагт дурсгалт газрыг тэмдэглэсэн байдал.




Зураг 3. Жаргалант хайрхан уул. Цагаан сайрын эхэн. 1. Хадны зургийн 1-р хэсэг, 2. Хадны зургийн 2-р хэсэг, 3. Хадны зургийн 3-р хэсэг, 4. Завсар өтгийн өвөлжсөө




Зураг 4. Цагаан сайрын хадны зургийн 1-р хэсэг



Зураг 5. Цагаан сайрын хадны зургийн 2-р хэсэг



Зураг 6. Цагаан сайрын хадны зургийн 3-р хэсэг



Зураг 7. Хадны зураг дахь нохойгоор ан хийж байгаа дүрслэлүүд.
1. Хар салаа VII, 2. Цагаан сайр, 3. Өлийн ам




График 1. Цагаан сайрын хадны зургийн дүр дүрслэлийг харьцуулсан тоон үзүүлэлт